

ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Төрийн албан хаагчийн ёс зүйн талаар алба хаагчдыг соён гэгээрүүлэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих, гарсан зөрчлийг таслан зогсоох, гүйцэтгэлийн үнэлгээнд болон сахилгын зөрчилд үндэслэн тухай бүр үр дүнд тохирсон хариуцлага тооцох ажлыг зохион байгуулах, хянах.

УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД:

Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр /2024-2030 он/”, Ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолоор батлагдсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам” Ёс зүйн дэд хорооны 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 10 дугаар тогтоол, 2024 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн “Журам батлах тухай” 13 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллах хүрээнд Онцгой байдлын байгууллагад 2025 онд дараах ажил, арга хэмжээг зохион байгууллаа. Үүнд:

- Онцгой байдлын ерөнхий газрын 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн №03 Ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх тухай албан даалгаврыг төв, орон нутгийн Онцгой байдлын анги, байгууллагад хүргүүлсэн.
- Онцгой байдлын ерөнхий газрын 2025.04.10-ны 03/985, 2025.05.13-ны 03/1375, 2025.08.25-ны 03/2351 албан бичгүүдээр үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгдсэн зохицуулалтаар хангаж ажилласан.
- Сар, улирал, хагас жил, жилээр төлөвлөгөөт ажлын хэрэгжилт, биелэлт болон төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлтийн бүртгэл мэдээллийг нэгтгэн гаргасан.

СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ХҮРЭЭНД:

Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх хүрээнд байгууллагын бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу 2025 онд “Төрийн алба хаагчийн ёс зүйн сургалт”-ыг 3664 алба хаагчийг хамруулан зохион байгуулсан нь нийт алба хаагчдын 70 орчим хувийг ёсзүйн сургалтад хамрууллаа.

Төрийн албан хаагчийн ёс зүй, авлигын эсрэг үйл ажиллагаа зэрэг нийт 8 төрлийн мэдээллийг /рийл-2, постер-4, мэдээ-2/ бэлтгэн “Онцгой байдлын ерөнхий газар” пейж хуудсанд байршуулахад давхардсан тоогоор 1.238.717 хүнд хүрсэн бол төв, орон нутгийн Онцгоой байдлын байгууллагын алба хаагчид сургалт, дадлагад ашиглаж, ёс зүйн чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүллээ.

Онцгой байдлын байгууллагаас сар бүр эрхлэн гаргадаг “Онцгой мэдээ” сонины 2025 оны **07** сарын дугаарт “Төрийн өлбан хаагчийн онцлог, ёсзүйн зарчим, эрхэмлэх зүйл” сэдвийн хүрээнд хуулийн зүйл, заалтыг тайлбарласан нийтлэл, **08** сарын дугаарт “Төрийн албан хаагчдын ёс зүйн төлөвшил тэдний хөгжлийн түвшинг илэрхийлэх хэмжүүр болдог” нийтлэл, **09** сарын дугаарт “Хариуцлагатай, чадварлаг, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх, иргэдийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөр”, **10** сарын дугаарт “Ёс зүйн дэд хорооны чиг үүрэг, гомдол хүлээн авах, шийдвэрлэх ажиллагаа нийтлэлийг тус тус бэлтгэн, хэвлүүлж, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын давхардсан тоогоор 12.000 алба хаагчдад хүргэсэн байна.

БУСАД:

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т заасны дагуу байгууллагын нийт албан хаагчдын санал хураалтаас олонхын дэмжлэг авч, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2024.10.29-ний өдрийн А/374 дүгээр тушаалаар байгуулагдсан ОБЕГ-ын дэргэдэх Ёс зүйн дэд хороо 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдан ажиллаж байна. Онцгой байдлын байгууллагын хэмжээнд Ёс зүйн 36 дэд хороо, 252 хүний бүрэлдэхүүнтэйгээр хууль тогтоомж, хөтөлбөр, албан даалгавар, албан бичгийн хэрэгжилтийг ханган ажиллалаа.


Тайлант хугацаанд зохион байгуулсан ажил, арга хэмжээний хүрээнд 2025 оны сахилга, ёс зүйн зөрчлийн тоог 2024 оны зөрчлийн тоотой харьцуулбал 3.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Ёс зүйн дэд хорооны гишүүд 3 сарын хугацаатайгаар ээлжлэн нарийн бичгийн даргын ажлыг гүйцэтгэн, тухайн улиралд хийсэн ажлаа тайлагнаж, Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын дагуу үйл ажиллагаа, гишүүдийн урамшуулал, чадавхжуулахтай холбогдох зардлыг тусган тухай бүрт олгосон байна.


ОБЕГ-ын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны 2025 оны ажил дүгнэх хурлыг 12 дугаар сарын 24-нд зохион байгуулж, төлөвлөгөөний хэрэгжилт болоод цаашид анхаарч ажиллах асуудлын талаар хэлэлцлээ.

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ЗУРГАН ТАЙЛАН

ОБЕГ-ын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны дарга, хурандаа Б.Үнэнбаатарын 04 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах тухай 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 03/2351 тоот албан бичгийг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагад хүргүүлсэн.




Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил:



Сургалт, сурталчилгааны, соён гэгээрүүлэх ажлын талаар:

Зураг-1



Зураг-2



Зураг-3

Views 16,783

Reach 7,177

Interactions 358

Reel followers 0

Watch time 1d 1h

Average watch time 6s

Views
Followers vs. non-followers

45% Non-followers 55% Followers

Audience retention
Most of your audience dropped off at the 0:04 mark and your average watch time is --:--

Boost post

Зураг-4

Reels

Create reel

Онцгой байдлын ерөнхий газар

Авлигаас ангид байлм

ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГА АВЛИГЫН ЭСРЭГ НЭГДЭЖ БАЙНА.

...НЭГДЭЖ... 110

212

3

125

Онцгой байдлын ерөнхий газар

Boost reel

Most relevant

О.Лхагваа О.Лхагваа

31w Like Reply Hide

Bihana hospital - Internationally Certified Hospital / 國際中醫針灸醫院 佛手醫院

31w Like Reply Hide


Л.Батбаатар 110

31w Like Reply Hide

Comment as Онцгой байдлын ерөнх...

17°C Mostly cloudy 3:31 PM 6/12/2023

Зураг-5



Зураг-6



Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт



